



ХОРТОН, ШАВЪЖТАЙ ТЭМЦЭХ НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч нарт:

Иллинойс мужийн хууль тогтоох байгууллагаас сургуулиуд дээрний тлэг хортон шавьж, хулгана, шоргоолж мэт хортонтой тэмцэх тухай хууль болон Иллинойс мужийн хортон шавьжтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах SBO527, SBO529 хуулийг баталсан. Энэ хуулийг сургууль хоёр төрлөөр хэрэгжүүлнэ: 1) Иллинойс мужын бүх сургуулиуд хортон шавьжтай тэмцэх нэгдсэн менежмент буюу IPM нэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2) сургуулиуд зарим төрлийн хортонтой тэмцэх хөтөлбөрийн талаар багш ажилчид, сурагч, эцэг эх, асран хамгаалагч нарт мэдэгдэх үүрэгтэй.

Хортон, шавьжтай тэмцэх нэгдсэн менежментийн (IPM) хөтөлбөр нь сургуулийн ажилтнуудтай харилцаа холбоо тогтоож, хяналт шалгалтыг явуулдаг. Хөтөлбөрийн гол зорилго нь хортон шавьжүүсэж болзошгүй сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлж, арилгах явдал юм. Хортонтой тэмцэх аргыг зөвхөн хортон, шавьжтай холбоотой асуудлыг арилгах шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлнэ. Оюутан сурагчид нэвтэрч, орох боломжтой газар, байрлалыг 34-р Дүүргийн энэхүү хөтөлбөрт хэрэгжүүлэхгүй.

Урхи, өгөөшөөс бусад хортон шавьжтай тэмцэх аргыг ашиглах шаардлагатай бол мэдэгдлийг ажлын хоёр хоногийн өмнө гаргана. Хэрэв эрүүл мэнд, эд хөрөнгөд аюултай байж болох тохиолдолд мэдэгдлийг түргэн хугацаанд гаргаж тараана. Мэдэгдэл тараах шаардлагын дагуу хортон шавьжтай тэмцэх зарим хориотой материалыг хэрэглэхээс өмнө тухайн сургуулийн бүх эцэг эх/асран хамгаалагч нарт бичгэн мэдэгдлийг тараасан байна.

Glenview 34-р Дүүргийн сургууль нь Андерсон хортон, шавьжтай тэмцэх байгууллагатай IPM-ийн үйлчилгээг авахаар гэрээ байгуулсан. Мэдээлэл, үйл ажиллагааны талаар асуух зүйл байвал Үйл



GLENVIEW SCHOOL DISTRICT 34

1401 Greenwood Road
Glenview, Illinois 60026
www.glenview34.org

ажиллагаа хариуцсан захирал Steve Ruelli (847)
998-5011 дугаарлуу, сургуулийн эрүүл мэндийн
ажилтан, сургуулийн захиралтай холбоо барина
уу.

Attea • Glen Grove • Henking • Hoffman • Lyon • Pleasant Ridge • Springman • Westbrook (847) 998-5000 •
(847) 998-5094 (Fax)